2026 оны 6-р сарын 2

ЖИЖҮҮРИЙН ПРОКУРОРЫН АЛБА ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫГ 24 ЦАГ ТАСРАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА



Прокурорын хяналтын чиг үүргийг тасралтгүй, шуурхай хэрэгжүүлэх, хойшлуулшгүй тохиолдолд тодорхой асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангуулах зорилгоор жижүүрийн прокурор 24 цагаар ажилладаг. Жижүүрийн прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран ажиллаж байна. Цахим залиланд өртсөн тохиолдолд цаг алдалгүй цагдаагийн байгууллагад хандсанаар прокурорын зөвшөөрлөөр тухайн дансыг царцааж, хөрөнгө хамгаалах арга хэмжээг авдаг.

Видео: https://www.youtube.com/watch?v=XxW8K-33i-E

Эх сурвалж: https://prosecutor-capital.greensoft.mn/post/170